



**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
САЛБАРЫН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ  
Д.БАЯРМААГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ/

ХЯНАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

/Ц.АРИУНСАНАА/

ТАЙЛАГНАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
АХЛАХ ШИНЖЭЭЧ

/Д.БАЯРМАА/



.....

(огноо)

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН САЛБАРЫН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ДАВААГИЙН БАЯРМААГИЙН  
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт /хувь/
A	1	2	3	4	5	6	7
<b>Зорилт 6.1:</b> "Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих"							
6.1.3	Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдээс гадаад хөрөнгө оруулалтын талаар төсвийн хязгаарт санал авч, 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт хүргүүлэх.	ШҮ1:2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөл; ШҮ2: ТХН-ийн тоо	Төслийн тоо-3	Төслийн тоо-4	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 8 төслийн хүрээнд гадаад зээл, тусламжаас 183,589.74 сая төгрөг, Улсын төсөв /Монголын талын хөрөнгө/-т 25.3 тэрбум төгрөгийн саналыг холбогдох төслийн танилцуулгын хамт 2026 оны төсвийн хязгаарт хүргүүлсэн. Гадаадын зээл тусламжаар хэрэгжих нийт 9 төслийн 2026 төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа тайлбар, саналыг өгч, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/1057 дугаартай албан бичиг /хавсралт 6/-ээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.	I-VI	100

A	1	2	3	4	5	6	7
<b>Зорилт 6.2:</b> “Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах”							
6.2.2	Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт 6 төслийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг хянан, баталгаажуулж, зарцуулалтад хяналт тавих, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын төсвийг хянан боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.	ШҮ1: Хэрэгжилтийн хувь; ШҮ2:Төслийн тоо;  ШҮ3:Батлагдсан ТХН-ийн төсөв.	2024 хэрэгжүүлсэн төслийн тоо-4; Гадаад зээл ашиглалтын хувь- 74%.  Батлагдсан ТХН-ийн төсөв-13;  ТХН-ийн урсгал зардлын гүйцэтгэлийн хувь-90 хувь.	2025 онд хэрэгжүүлэх төслийн тоо-3,  Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн хувь 10%.  Батлагдсан ТХН-ийн төсөв-6 удаа;  ТХН-ийн урсгал зардлын гүйцэтгэлийн хувь-30%	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа дараах 3 төслийн хүрээнд 2025 оны хөрөнгө оруулалтад 111.5 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд  гүйцэтгэлд өссөн дүнгээр 10.14 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хянаж, шийдвэрлүүлсэн. Хэрэгжилтийн хувь 10% байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн 1, 2 улирлын үйл ажиллагааны зардлын 6 удаагийн төсвийг хянаж баталгаажуулан СЯ-нд хүргүүлсэн ба хэрэгжилт 30%.  Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 3 багц ажлын гэрээний нэмэлт, өөрчлөлтийг 2025/131, 2025/132, 2025/133 баталгаажуулж, Сангийн яаманд хүргүүлсэн.	I-VI	90
6.2.4	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй 6 төслийн гэрээ хэлэлцээрийн дагуу импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ чөлөөлөлтөд хяналт тавьж, шийдвэрлүүлэх, дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын жагсаалт батлуулах арга хэмжээ авах.	ШҮ1:Импортын хүсэлтийн албан бичгийн тоо, ; ШҮ2:Гааль, НӨАТ-ын-тооцоо нийлсэн акт ШҮ3:Сангийн яаманд хүргүүлсэн санал.	2024 онд батлуулсан импортын жагсаалт -3;  2024 оны Импортын бараа материалын хэрэгжилтийн хувь-70%	2025 онд батлуулсан импортын жагсаалт -3;  2025 оны Импортын бараа материалын хэрэгжилтийн	Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан журмын дагуу гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 төслийн хүрээнд нийт 33,8 тэрбум төгрөгийн импортоор оруулж ирэх бараа материалын жагсаалтыг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан. 2025 оны хагас жилийн байдлаар 47 хувь буюу нийт 15.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий импортын бараа материалыг гааль, НӨАТ-ын чөлөөлөлтөд хамруулсан.	I-VI	100

A	1	2	3	4	5	6	7
			<p>Дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх санал-1.</p>	<p>хувь-45%-дээш Дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх санал-1.</p>	<p>Нийт ирүүлсэн хүсэлт 30, үүнээс 28 хүсэлт буюу 93%-ийг шийдвэрлэсэн. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 4 төслийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар импортоор оруулж ирсэн бараа материалын тооцоог нийлж баталгаажуулсан.</p> <p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны А/76 тушаал батлуулсан. Төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулж, 2025 оны 07 дугаар Төслийн удирдах хорооны зөвлөмжийг батлуулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын А/76 тушаалаар хөрөнгө гаргах шийдвэрийг баталгаажуулсан. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл /МОН-3244/3245/-ийн А1 багц ажлын гүйцэтгэгч “Людвиг Пфайфер” ХХК-ийн түр горимын нөхцөлтэйгөөр 2020 онд импортолсон тоног төхөөрөмжийн хуульд заасан түр горимын хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан түр горимоор оруулж ирсэн тоног төхөөрөмжүүдийн гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай нийт 171,387,715.36 төгрөгийн гаалийн татварын зардлыг шийдвэрлүүлсэн.</p>		

A	1	2	3	4	5	6	7
6.2.5	Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн Төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах.	<p>ШҮ1: ТУХ-ны хурлын тоо /2-оос доошгүй удаа-Төсөл тус бүр/;</p> <p>ШҮ2:Төслийн удирдах хорооны шийдвэр-тогтоол, зөвлөмж;</p> <p>ШҮ3:ТУХ-аас гарсан шийдвэрийн биелэлт /хагас, бүтэн жил/.</p>	<p>Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн тоо 4;</p> <p>Төслийн удирдах хорооны хурлыг 22 удаа зохион байгуулсан.</p> <p>ТУХ-оос нийт 28 үүрэг даалгавар өгөгдсөн ба шийдвэрийн биелэлт-95%.</p>	Төслийн удирдах хорооны хурлын тоо 6 удаа; ТУХ-ны шийдвэр-зөвлөмж, тогтоол; ТУХ-ны шийдвэрийн биелэлт 60-70 хувь.	<p>Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 7 төслийн Төслийн удирдах хорооны хурлыг 12 удаа зохион байгуулсан. Төслийн захирлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Б/28 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. ТУХ-ны зөвлөмжийн дагуу өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт энэ оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 80 хувьтай байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлуулсан.</p> <p>Төслийн удирдах хорооны хурлын шийдвэрийг тухай бүр баталгаажуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн. Төслийн удирдах хорооны шийдвэр-тогтоол, зөвлөмж /12/-ийг баталгаажуулан тухай бүр Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн.</p> <p>Сангийн сайдын А/30 тушаалаар холбогдох жуарм шинэчлэгдсэнтэй холбогдуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн 30 албан хаагчийн Хөлсөөр ажиллах гэрээ"-г шинэчлэн баталгаажуулан ажилласан.</p>	I-VI	100
6.2.6	Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр мөн Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлэх	<p>ШҮ1:Төслүүдийн хөрөнгийн өмчлөлийн жагсаалт;</p> <p>ШҮ2:ТӨБЗГ-т хүргүүлсэн</p>	2024 оны хөрөнгийн өмчлөлийн судалгаа; Гадаад зээл, тусламжийн	2025 оны хөрөнгийн өмчлөлийн судалгаа; Дууссан төслийн тоо-6;	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгаврын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт гадаад зээл,	I-XII	95

<p>саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгуулах.</p>	<p>хөрөнгийн өмчлөлийн санал;</p>	<p>хөрөнгөөр хэрэгжиж дууссан төслийн тоо-4; Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн хэмжээ нийт 158,419.83 сая төгрөг. Хэрэгжилт-25%</p>	<p>ТӨБЗГ-т хүргүүлсэн хөрөнгийн өмчлөлийн санал-4. Хэрэгжилт-70 хувиас дээш.</p>	<p>тусламж болон улсын төсвийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хөрөнгийн өмчлөлийн 2020-2025 оны судалгааг он оноор нэгтгэн гаргасан. Мөн тус яамны холбогдох газрууд, төсөл хэрэгжүүлэх нэгжид хөрөнгийн бүртгэлийг "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн систем" болох <a href="http://pcsp.gov.mn">http://pcsp.gov.mn</a> цахим системд байршуулах арга хэмжээг авахад хамтарч ажиллах талаар мэдээллийг хүргүүлсэн. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төслүүдийн хөрөнгийн өмчлөлийн судалгааг гарган удирдлагад танилцуулсан. Энэ оны хагас жилийн байдлаар дараах 4 төслийн хүрээнд нийт 137.77 тэрбум төгрөгийн хөрөнгийг нийслэл, орон нутгийн өмчлөлд бүртгүүлэх 4 саналыг ТӨБЗГ-т албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр 2013-2023 онд хэрэгжүүлж дуусгасан 157.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 87 төсөл, арга хэмжээ, 2024 онд дуусгасан 113.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 51 төсөл, арга хэмжээ буюу нийт 271.3 тэрбум төгрөгийн өртөгтэй 138 төсөл, арга хэмжээний хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлүүлэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.</p> <p>Эдгээр төсөл, арга хэмжээний хүчин чадал болон хөрөнгө тус бүрийн үнэ өртгийг нарийвчлан ирүүлэх чиглэлийн дагуу Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газар, Барилгын хөгжлийн төвд холбогдох</p>		
---	-----------------------------------	--	--	---	--	--

					<p>судалгааг гарган өгч, энэ дагуу нийт 78.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн баримт материалыг бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2/3936, 2/3367, 2/4286, 2/4251, 2/4253, 2/4255 дугаартай албан бичгээр дахин хандсан.</p> <p>Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон нийт 31.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Хүннү хотын захиргааны өмчлөлд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу тус яамны “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А160, А/161 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн байгуулсан.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 396 дугаар тогтоолын хүрээнд “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хурлыг 2 удаа зохион байгуулж, яамны дансанд бүртгэлтэй 106.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах санал дүгнэлтийг гаргуулсан. Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж байгаатай холбогдуулан гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 4 төслийн “Төсөл</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>хэрэгжүүлэх нэгж"-ийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн судалгааг авч үүнээс 150.8 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг актлах саналыг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Тус яамны Хуулийн хэлтэст "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах" төслийн хүрээнд бий болсон "Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргаа"-ны бүртгэлд байгаа 1,208.0 сая төгрөгийн үлдэгдэл хөрөнгийн үнэлгээ нь хууль тогтоомжид нийсэн эсэх, гэмт хэргийн шинжтэй эсэхэд хуулийн дүгнэлт авахаар холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.</p>		
--	--	--	--	--	---	--	--

**Зорилт 6.3:** Төрийн сангийн гүйлгээг гүйцэтгэх, тайлан, баланс гаргах.

6.3.5	<p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангуулах.</p>	<p>ШҮ1:Батлагдсан төлөвлөгөө; ШҮ2:Хэрэгжилтийн хувь</p>	<p>- Төлөвлөгөө батлуулах-1; Хэрэгжилтийн хувь 30-50 хувь</p>	<p>Хэрэгжилтийн хувь 90 хувь</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ." гэж заасны дагуу тус газарт хандаж, улмаар уг төслийн хүрээнд бий болсон нийт 3.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 491 дүгээр тогтоолоор "Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэр гаргуулсан.</p> <p>Энэ дагуу хөрөнгийг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулах явцад "Хангай хотхон" ХХК-аас 2 удаа шүүхэд хандсаны улмаас хөрөнгийн өмчлөлийн асуудал удааширалтай болсон.</p> <p>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 128/ШШ2023/0032 дугаар шийдвэр,</p>	IX-XII	70
-------	--	---	---	----------------------------------	--	--------	----

					Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 221/МА2023/0322 дугаар магадлалаар тус тус Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 491 дүгээр тогтоолоор төрийн өмчийг бүртгэх, хөрөнгө хүлээлцэхээр шийдвэрлэснийг хууль бус гэж үзээгүй учир дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/128 дугаар тушаалаар "Ажлын хэсэг" ажиллаж байна. Ажлын хэсгийн байгуулагдан хурлыг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хуралдуулахаар төлөвлөсөн		
A	1	2	3	4	5	6	7
					бөгөөд ашиглагч байгуулагын хүсэлтийн дагуу хурлыг 2 удаа хойшлуулсан.		

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

№	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт /хувь/
A	1	2	3	4	5	6	7
1	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-1	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна. /90%-с дээш/.	-	Хэрэгжилтийн хувь 90 хувь	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар "Сумын төвлөрсөн гадна дулаан хангамж, дулаан механикийн барилга угсралтын ажил /Дорнод, Чойбалсан сум" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласан. Тендерийн баримт бичгийг баталгаажуулан 2025 оны 03 дугаар	III-VI	100

					сарын 26-ны өдөр зарласан. Тендерийн нээлтийг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр нээж, үнэлгээг хийж, үнэлгээний хорооноос гаргасан гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. Мөн холбогдох мэдэгдлийг цахимд байршуулж, холбогдох баримт бичгийг архивын нэгж бүрдүүлэн Төрийн захиргааны удирдлагын газрын архивын ажилтанд хүлээлгэн өгсөн. Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн дараах асуудлуудад холбогдох саналаа өгч, тухай зөвлөмжөөр тайлагнаж ажилласан. Үүнд:		
A	1	2	3	4	5	6	7
2	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-2	ШҮ1:Хурлын тоо, санал;  ШҮ2:Зөвлөлийн хурлын хэрэгжилт, үр дүн	-	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн зөвлөмж, Хурлын /90 дээш хувь/ оролцоо,	1. Яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтын асуудлаар 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хуралд оролцсон. 4 албан хаагчийн тусгай шалгалтыг зохион байгуулахаар шийдвэрлэхэд санал өгсөн. 2. Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн ээлжит хуралд оролцож, холбогдох саналыг өгсөн. /Төрийн албаны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох /; 3. Яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтын асуудлаар 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурал, 2025	I-XII	100

					оны 06 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурал, 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хуралд тус тус оролцож, саналаа өгсөн. /15 албан хаагчийн тусгай шалгалтыг зохион байгуулах/.		
3	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-3	ШҮ1:Үнэлгээний хорооны хурлын тоо ШҮ2:Үнэлгээний хорооны хэрэгжилт, үр дүн	-	Тендер шалгаруулалтын явц, үнэлгээнд өгсөн санал; Хурлын протокол, Хурлын оролцоо-90 дээш хувь	Эдийн засгийн хөгжлийн яамны харьяа Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хэтөлбөр"-ийн 1 дүгээр үе шатны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан "Төслийн бүрэлдэхүүн 2-ын хэрэгжилт "МАА, бэлчээрийн менежмент, техникийн дэмжлэг	III-X	100
A	1	2	3	4	5	6	7
					үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, Олон улсын нээлттэй тендерийг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/73 дугаар тушаалаар байгуулсан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамыг төлөөлж, Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан. Үнэлгээний Хорооны эхний хурал 2025 оны 3-р сарын 24-ний өдөр болж, ажлын даалгавар, төсвийн задаргаатай танилцсан. Үүнээс хойш нийт 3 удаагийн хуралд оролцож, үнэлгээ хийж, холбогдох саналаа тусгуулж, холбогдох үнэлгээний хорооны хурлын протокол, үнэлгээг баталгаажуулан ажилласан.		

4	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-4	ШҮ1:Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт /90 хувиас дээш/	-	Засгийн газрын тогтоол; Төсөвт өртөг-27.35 сая евро	Төслийн нэмэлт санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсын зээлийн хөрөнгөөр "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн хэрэгжүүлж буй "Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн өргөтөл, шинэчлэл"-ийн ажлын өртгийг 7,8 сая еврогоор нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолын төслийн саналыг холбогдох баримт материал, танилцуулгыг бэлтгэн хүргүүлж, Засгийн газрын 2025 оны 113 тогтоолоор төслийн төсөвт өртөг 27.35 сая еврогоор нэмэгдүүлэн баталсан.	IV	100
5	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-5	ШҮ1:Нэмэлт хөрөнгө	-	Засгийн газрын тогтоол, Нэмэлт хөрөнгө.	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц"төслийн "Орон сууцны хороолол" багц ажлын хүрээнд байгуулагдсан "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний төсөл хэрэгжүүлэгч "Бэрэн групп" ХХК, "Цагаан хуаран консалтинг" ХХК-д тус тус холбогдуулан гаргасан арбитрын маргааныг шийдвэрлүүлэхтэй холбогдуулан "Хөрөнгө гаргах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, холбогдох яамдаас санал авч нэгтгэн, 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/572 дугаартай албан бичгийг МУ-ын Шадар сайдад хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 112 дугаар	II-IV	100

					тогтоолоор 872.03 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргуулахаар шийдвэрлүүлсэн.		
6	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-6	ШҮ1:Шүүхийн хуралд шаардлагатай баримт	-	Гэрээ, санхүүгийн холбогдох баримт	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн"Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн "Дархан хотын бохир ус цэвэршүүлэх байгууламж, насос станц болон 12 сарын зүгшрүүлэлт" ажлын ерөнхий гүйцэтгэгч "Пфайфер-Эмит" түншлэлтэй байгуулсан А1/158 дугаартай гэрээ, гэрээг цуцалсан шийдвэр болон шүүх хуралдаанд шаардлагатай баримт бичгийг Хуулийн хэлтэст дотоод албан бигчээр өгч хамтран ажилласан.	VIII	100
7	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-7	ШҮ1:Төслийн явцын мэдээлэл, тулгамдсан асуудлууд	-	Төслийн мэдээлэл /Танилцуулга- ppt/	Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах 3 төслийн танилцуулгыг бэлтгэн сайдын зөвлөх, удирдлагуудад танилцуулсан. Үүнд: - Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл; - Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл; - Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл.	IV	100
8	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-8	Ёс зүйн сургалт	-	Сургалтын зардлын төсөв, Сургалтын тайлан	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.3, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.1.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Удирдлагын академи болон Ёс зүйн хороо хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш" хөтөлбөрт хамрагдаж төгсөн улмаар тус яамны	III	100

					Ёс зүйн дэд хорооны болон харьяа байгууллагын дэд хороодын гишүүдэд зориулан 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Ёс зүйн сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтад хамруулахаар төлөвлөсөн 13 суралцагч бүгд хамрагдаж, идэвхитэй оролцсон.		
9	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-9	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна.	-	Тайлан.	Сангийн яамнаас зохион байгуулж буй “Хөрөнгийн үнэлгээчний эрх олгох шалгалт”-ын комиссд гишүүнээр томилогдож, хуулийн болон мэргэжлийн шалгалтад хянагчаар 2өдөр ажилласан. Энэ дагуу шалгалтын үр дүнгийн тайланг баталгаажуулсан.	X	100
10	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-10	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна.	-	Төлөвлөгөөний биелэлт хангах	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/122 дугаар тушаалаар “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл хангах салбар комиссын бүрэлдэхүүн”-нд гишүүнээр томилогдож ажилласан. Улсын үзлэгийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу өгсөн чиглэлийн дагуу газрын албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангуулах, 2023-2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг албан хаагч бүрээр авч нэгтгэн архивын нэгж бүрдүүлсэн.	I-XII	100
11	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-11	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна.	-	Төслийн холбогдох санхүүжилтийн мэдээ, тайлан болон баримт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас яамны хэмжээнд нийт 5 төсөл, арга хэмжээнд хяналт хийхтэй холбогдуулан БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн барилга	VII-X	100

					угсралтын санхүүжилт, холбогдох баримтыг бэлтгэн өгсөн.		
12	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-12	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна.	-	Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө-1, тайлан-2 удаа.	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулсан /2 удаа /, 2025 оны гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, баталгаажуулсан.	I, VI, XII	100
13	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-13	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна.	-	УИХ, Засгийн газрын тогтоолын төслийн санал Зөвлөмжийн биелэлт;	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, өгсөн зөвлөмжийн биелэлтийг газрын хэмжээнд нэгтгэн гаргаж Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 04/1252 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн хууль тогтоомж, тогтоолын хэрэгжилтийн тайланг газрын албан хаагчдаас авч нэгтгэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Шадар сайд, 5 яамдаас ирүүлсэн УИХ, Засгийн газрын тогтоолын нийт 17 төслүүдэд санал хүргүүлсэн.	I-XII	100
14	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар-14	ШҮ1: Ирсэн, явсан албан бичиг, өргөдөл гомдлын тоо; ШҮ2: Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	-	Албан бичиг, өргөдөл гомдлуудыг хугацаанд нь хариу төлөвлөж, хүргүүлэх.	Хариуцсан асуудалтай холбоотой нийт 188 албан бичиг ирсэн бөгөөд 189 албан бичгээр хариу хүргүүлсэн байна. Өргөдөл, гомдол ирээгүй, албан бичгийн шийдвэрлэлтийн хувьд хариу өгөөгүй албан бичиг байхгүй байна. Газар, хэлтэсийн хүрээнд нийт 8 дотоод албан бичиг ирүүлсэн. Мэдээлэл авах, санал авах, хамтран ажиллах талаар тус яамны нэгжүүдэд 18 бичгээр хандсан байна.	I-XII	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт /хувь/
А	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх хүрээнд сургалтад хамрагдах	Ёс зүйн мэдлэг	-	Ёс зүйн сургагч багш болох	Удирдлагын академи болон Ёс зүйн хорооноос анх удаа зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш" бэлтгэх сургалтад амжилттай суралцаж "Ёс зүйн сургагч багш" үнэмлэх гэрчилгээ (№Z1415) авсан.	IV	100
2	Хариуцсан асуудлын хүрээнд сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдах мэдээлэл авах	-	Системийн хөгжүүлэлттэй танилцах	2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь" сургалтад хамрагдсан.	X	100
3	Мэдээлэл технологийн чиглэлийн хүрээнд сургалтад хамрагдах	Гэрчилгээ	Анхан шат	Өгөгдөл боловсруулах орчин цагийн шинэ программ суралцан Дунд шатны мэдлэгтэй болох	Санхүү, Эдийн засгийн сургуулийн "Өгөгдлийн шинжилгээ Power BI" дунд шатны сургалтад амжилттай суралцаж, Өгөгдөл боловсруулах чадамжын үнэлгээний гэрчилгээ (№C20251380)-г авсан.	IX	100
4	Монгол бичгийг бие даан суралцах	Монгол бичгийн цахим сургалт	Анхан шат	Сургалт	Удирдлагын академийн Монгол бичгийн 40 цагийн сургалтад цахимаар суралцаж холбогдох гэрчилгээ (№lagx13aw4x)-г авсан. Кирилл бичвэрийг монгол бичиг рүү хөрвүүлдэг "Кимо" онлайн программыг туршиж үзсэн. Монгол бичгийн дунд шатны сургалтын хүрээнд монгол бичгээр компьютерт эх бэлтгэх мэдлэг, хөрвүүлэг хийх	VIII	90

					аргад суралцаж байна.		
--	--	--	--	--	-----------------------	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:  
СХОГ-ын ахлах шинжээч  
(Албан тушаал)



Д.Баярмаа  
(Нэр, гарын үсэг)

2025.12.19  
.....  
(Огноо)

**САЛБАРЫН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ  
ДАВААГИЙН БАЯРМААГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
<b>Зорилт 1: "Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих" хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт:</b>					
1	Арга хэмжээ 1.1. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдээс гадаад хөрөнгө оруулалтын талаар төсвийн хязгаарт санал авч, 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт хүргүүлэх.	55	8	63	63
<b>Зорилт 2: "Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах" хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт:</b>					
1	Арга хэмжээ 2.1. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт 3 төслийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг хянан, баталгаажуулж, зарцуулалтад хяналт тавих, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын төсвийг хянан боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	55	8	63	63
2	Арга хэмжээ 2.2. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй 6 төслийн гэрээ хэлэлцээрийн дагуу импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ чөлөөлөлтөд хяналт тавьж, шийдвэрлүүлэх, дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын жагсаалт батлуулах арга хэмжээ авах	55	8	63	63
3	Арга хэмжээ 2.3. Барилга, хот байгуулалтын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн гэрээ хэлэлцээрийн дагуу импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ чөлөөлөлтөд хяналт тавьж, шийдвэрлүүлэх, дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтыг батлуулах.	56	8	64	64
4	Арга хэмжээ 2.4 Салбарын чиглэлээр гадаад болон ногоон эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах загвар, схемийг төрөлжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч нарт таатай нөхцөлийг бий болгох асуудлыг хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулах.	57	7	64	64
5	Арга хэмжээ 2.5. Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр мөн Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлэх саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлж, нягтлан бодох бүртгэлд тусуулах.	56	7	63	63
<b>Зорилт 3: Төрийн сангийн гүйлгээг гүйцэтгэх, тайлан, баланс гаргах.</b>					
1	Арга хэмжээ 3.1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах.	57	5	62	62

2	Арга хэмжээ 3.2. Төсөл хэрэгжүүлэх нэгжгүй БНАУ-ын зээлээр хэрэгжсэн 3 төслийн Санхүүгийн тайланд шаардлагатай гадаад зээл, ашиглалтын тооцоо нийлэх	57	7	64	64
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт					
1	Үдирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх	60	8	68	68
<b>Дундаж оноо:</b>				<b>63.8</b>	<b>63.8</b>

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	Өгөгдөл боловсруулах Power BI сургалтад хамрагдана.	100	14.2	14.2
2	Монгол бичгийг бие даан суралцана.	70	13.3	13.3
<b>Дундаж оноо</b>			<b>13.8</b>	<b>13.8</b>

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1		3
1	Хандлага, ёс зүй	6	6
2	Дүн шинжилгээ хийх	6	6
3	Асуудал шийдвэрлэх	6	6
4	Хариуцлагатай байдал	6	6
5	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	6	6
7	Мэргэжлийн ур чадвар 2.		
8	Мэргэжлийн ур чадвар 3.		
<b>Дундаж оноо</b>		<b>6.2</b>	<b>6.2</b>

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)


Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	0
1	Хандлага, ёс зүй	8
2	Багаар ажиллах	8
3	Харилцаа	8
<b>Дундаж оноо</b>		<b>8</b>

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	63.8
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.8
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.2
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8.0
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
<b>Нийт оноо =</b> ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		<b>91.8</b>

### Үнэлгээ өгсөн:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Нэгжийн дарга  
  
 (даргын үсэг)


Ц.АРИУНСАНАА

..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

СХОГ-ын Ахлах шинжээч

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

  
.....  
(гарын үсэг)

Д.БАЯРМАА

..... (огноо)

**Үнэлгээг хянасан:**

**Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

Төрийн захиргааны удирдлагын газрын  
даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

.....  
(гарын үсэг)

Б.БАТ-ЭРДЭНЭ

..... (огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

ТЗУГ-ын Хүний нөөц, шагнал  
хариуцсан ахлах шинжээч

.....  
(гарын үсэг)


Т.ЯНЖМАА

..... (огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:**

Төрийн нарийн бичгийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Төсвийн шүүд захирагч**

  
.....  
(гарын үсэг)

М.БАЯРАА

..... (огноо)